

“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

**Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудын
кадастрын зураг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон
шалгаруулах тендерийн баримт бичиг**

Тендер шалгаруулалтын дугаар: ХАН№19/51

НЭГ. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудын кадастрын зургийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг 2019 оны 07-р сарын 25-н өдрийн 14 цагаас өмнө ирүүлэх.

Үнийн саналтын нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2019 оны 07-р сарын 25-ны өдрийн 14 цаг 30 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Тендерийн баримт бичгийн дагуу холбогдох материалуудыг бүрдүүлж төрийн худалдан авах ажиллагааны цахим системд оруулж бидэнтэй хамтран ажиллахыг хүсье. /Тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нэвтэрч авна уу/

Хаяг: Улаанбаатар хот, Багануур дүүрэг, үйлдвэрийн хэсэг, “БЗӨБЦТС” ТӨХК-ийн конторын байр 202 тоот өрөө.

Утас: 99105839

Факс: 70210167

ХОЁР. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ГУРАВ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

| | |
|---------------------------------------|---|
| <p>ТӨӨЗ-ны холбогдох заалт</p> | <p align="center">Шалгуур үзүүлэлт /Бүрдүүлэх материал/</p> |
| <p>ТӨӨЗ 1.1</p> | <ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл / ажил гүйцэтгэх гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт / 2. Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: Геодези, зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл 3. Маягтын дагуу үнийн санал ирүүлнэ. 4. Тендерийн баримт бичгийг төрийн худалдан авах ажиллагааны цахим хаягаар ирүүлнэ. 5. Сүүлийн нэг жилийн буюу 2018 оны санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ. 6. Ажил хийгдэх хугацаа: 60 хоногоос ихгүй байна. 7. Одоо хэрэгжүүлж буй гэрээний жагсаалтыг маягтын дагуу ирүүлнэ. |
| <p>ТӨӨЗ 2.1</p> | <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Энэхүү бараа материал нийлүүлэх тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn цахим хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа: Огноо:2019 оны 07 дугаар сарын 25 өдөр Цаг: 14 цаг 00 минут.</p> |
| <p>ТӨӨЗ 2.1</p> | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Багануур дүүрэг 3-р хороо Үйлдвэр хэсэг “БЗӨБЦТС” ТӨХК өөрийн байр Давхар болон өрөөний дугаар: “БЗӨБЦТС” ТӨХК –н өөрийн байр 2-р давхар 202 тоот Огноо: 2019 оны 07 дугаар сарын 25-ны өдөр Цаг: 14 цаг 30 минут</p> |
| <p>ТӨӨЗ 2.3</p> | <ol style="list-style-type: none"> 1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар ирүүлнэ. (Тусгай зөвшөөрлийн хамт) 2. НӨАТ төлөгч бол гэрчилгээний хуулбар. НӨАТ төлөгч биш бол энэ тухай албан тоот ирүүлнэ. 3. Сүүлийн хоёр жилийн нийт борлуулалтын орлого тендерийн төсөвт өртгөөс багагүй байна. /Сангийн сайдын 2013 оны тушаалын хавсралт “Цахим тендер зохион байгуулах журмын 1.2 дагуу цахим тендерийн лавлагааг үндэслэнэ/. 4. Одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх шүүхийн төрөлжсөн архив, ШШПГЕГ-ын тодорхойлолтуудыг ирүүлнэ. 5. Тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байх, мөн татварын тодорхойлолтыг www.tender.gov.mn цахим сайтын лавлагааг үндэслэнэ. |
| <p>ТӨӨЗ 6.2</p> | <p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий байна. ХА.№19/51, Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудын кадастрыг зураг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер. Багцтай эсэх: Үгүй</p> |

ДӨРӨВ. КАДАСТРЫН ЗУРАГ ХИЙГДЭХ ЦДАШ-н ЖАГСААЛТ

| № | Шугамын эхлэлийн дэд станц | Шугамын ША-ны нэр | Хүчдлийн түвшин (кВ) | Шугамын урт (км) | Тулгуур тоо | Тайлбар |
|-----------------------------|--|----------------------------|----------------------|------------------|-------------|---|
| 1 | 220/110/35 кВ-ын Багануур дэд станц | 35 кВ Байдлаг ЦДАШ | 35 | 5 | 36 | Багануур дүүрэг |
| 2 | 35/10 кВ-ын Байдлаг дэд станц | 35 кВ Хэрлэнбаянулаан ЦДАШ | 35 | 86.2 | 703 | Хэнтий аймгийн Хэрлэнбаянулаан тосгон |
| 3 | | 35 кВ Цэнхэрмандал ЦДАШ | 35 | 66 | 353 | Хэнтий аймгийн Цэнхэрмандал сум |
| 4 | 35 кВ-ын Хэрлэнбаянулаан АШ-ын Т-664 салбарласан | 35 кВ Тариабригад ЦДАШ | 35 | 5.5 | 47 | Хэнтий аймгийн Хэрлэнбаянулаан тосгоны нутаг дэвсгэрт |
| 35 кВ ЦДАШ-ын нийт урт /км/ | | | | 157.7 | 1103 | |
| 5 | 35/10 кВ-ын Байдлаг дэд станц Яч№5 | 10 кВ Мөнгөнморьт ЦДАШ | 10 | 59.8 | 563 | Төв аймгийн Мөнгөнморьт сум |
| 6 | 35/10 кВ-ын Хэрлэнбаянулаан дэд станц Яч№1 | 10 кВ Дэлгэрхаан ЦДАШ | 10 | 36 | 432 | Хэнтий аймгийн Дэлгэрхаан сум |
| 7 | 10 кВ-ын Жаргалтхаан ЦДАШ | 10 кВ Жаргалтхаан ЦДАШ | 10 | 42.5 | 529 | Хэнтий аймгийн Жаргалтхаан сум |
| 8 | 35/10 кВ-ын Хэрлэнбаянулаан дэд станц Яч№5 | 10 кВ Сумын төв ЦДАШ | 10 | 0.7 | 10 | Хэнтий аймгийн Хэрлэнбаянулаан тосгон |
| 10 кВ ЦДАШ-ын нийт урт /км/ | | | | 139 | 1534 | |
| 1 | 35/6 кВ Цэнхэрмандал дэд станц | 6 кВ Төв ЦДАШ | 6 | 2 | 29 | Хэнтий аймгийн Цэнхэрмандал сум |
| 2 | | 6 кВ Хужжаан ЦДАШ | 6 | 4 | 57 | |
| 3 | | 6 кВ Радио Реле ЦДАШ | 6 | 5 | 71 | |
| 4 | РП-1 | Яч№12 6кВ ЦДАШ | 6 | 1.2 | 17 | Багануур дүүрэг |
| 5 | | Яч№13 6кВ ЦДАШ | 6 | 1.1 | 15 | |
| 6 | РП-2 | Яч№7 6кВ ЦДАШ | 6 | 2.1 | 30 | |
| 7 | | Яч№16 6кВ ЦДАШ | 6 | 5 | 71 | |
| 8 | 110/6 кВ Хот дэд станц | Яч№16 6кВ ЦДАШ | 6 | 17 | 242 | Багануур дүүрэг |
| 9 | | Яч№26 6кВ ЦДАШ | 6 | 0.8 | 12 | |
| 10 | | Яч№27 6кВ ЦДАШ | 6 | 2.6 | 36 | |
| 11 | Төв-110/6кВ дэд станц | Яч№19 6кВ ЦДАШ | 6 | 16.2 | 263 | Багануур дүүрэг |
| 12 | | Яч№38 6кВ ЦДАШ | 6 | 18 | 257 | |

| | | | | | | |
|---------------------------|------------------------|------------------------------|-----|--------------|-------------|---------------------------------------|
| 13 | | Яч№2 6кВ ЦДАШ | 6 | 1.3 | 18 | |
| 14 | | Яч№12 6кВ ЦДАШ | 6 | 1.3 | 18 | |
| 15 | | Яч№21 6кВ ЦДАШ | 6 | 18 | 219 | |
| 16 | | Яч№37 6кВ ЦДАШ | 6 | 21 | 78 | |
| 17 | | Яч№14 6кВ ЦДАШ | 6 | 15 | 187 | |
| 6кВ ЦДАШ-ын нийт урт /км/ | | | | 131.6 | 1620 | |
| 1 | КТП-59 | 2-р хороо 0.4 кВ ЦДАШ | 0.4 | 2.2 | 57 | Багануур дүүрэг |
| 2 | КТП-60 | 2-р хороо 0.4 кВ ЦДАШ | 0.4 | 2.4 | 60 | |
| 3 | КТПН-12 | Хуцаа 0.4кВ ЦДАШ | 0.4 | 5.3 | 120 | |
| 4 | КТП-17 | Жаргалант 0.4 кВ ЦДАШ | 0.4 | 4.1 | 70 | |
| 5 | КТП-14 | Рашаант 0.4 кВ ЦДАШ | 0.4 | 3.2 | 80 | |
| 6 | КТП-13 | Багагүн 0.4 кВ ЦДАШ | 0.4 | 4.78 | 110 | |
| 7 | КТП-130 | Ихгүн 0.4кВ ЦДАШ | 0.4 | 5 | 110 | |
| 8 | КТП-13 | Ихгүн 0.4кВ ЦДАШ | 0.4 | 5 | 110 | |
| 9 | ТП-15 | Сургалтын задгай 0,4 кВ ЦДАШ | 0.4 | 6.3 | 162 | |
| 10 | КТП-18 | Нарийн 1-18 0.4 кВ ЦДАШ | 0.4 | 4.5 | 112 | |
| 11 | АТП-32 | Нарийн 18-25 0.4 кВ ЦДАШ | 0.4 | 4.1 | 70 | |
| 12 | КТП-19 | Байдлаг 0.4 кВ ЦДАШ | 0.4 | 4.1 | 70 | |
| 13 | КТП-19 | Хэрлэн 0.4 кВ ЦДАШ | 0.4 | 3.5 | 87 | |
| 14 | ТП-30 | Хилчин хороолол 0.4 кВ ЦДАШ | 0.4 | 1 | 23 | |
| 15 | АТП-58 | Төмөр зам задгай 0.4 кВ ЦДАШ | 0.4 | 3 | 72 | |
| 16 | ТП-31 | Промбаз 0.4 кВ ЦДАШ | 0.4 | 1.8 | 38 | |
| 17 | Цэнхэрмандал д АТП-1-3 | Гэр хороолол 0.4 кВ ЦДАШ | 0.4 | 8.5 | 204 | Хэнтий аймгийн Цэнхэрмандал сум |
| 18 | Хэрлэнбаянулаан АТП-1 | Гэр хороолол 0.4 кВ ЦДАШ | 0.4 | 2.8 | 63 | Хэнтий аймгийн Хэрлэнбаянулаан тосгон |
| 19 | Дэлгэрхаан АТП-1, 2 | Гэр хороолол АТП-1 | 0.4 | 4 | 113 | Хэнтий аймгийн Дэлгэрхаан сум |
| 20 | | Гэр хороолол АТП-2 | 0.4 | 3.3 | 87 | |
| 21 | Жаргалтхаан АТП-1,2 | Гэр хороолол АТП-2 | 0.4 | 2.8 | 74 | Хэнтий аймгийн Жаргалтхаан сум |
| 22 | | Гэр хороолол АТП-1 | 0.4 | 6.9 | 160 | |
| 23 | Мөнгөнморьт АТП-1-3 | Гэр хороолол АТП-1 | 0.4 | 10.2 | 323 | Төв аймгийн Мөнгөнморьт |

| | | | | | | |
|----|-----------|-------------------------|-----|-----|----|-----------|
| 24 | | Гэр хороолол АТП-2 | 0.4 | 2 | 61 | сум |
| 25 | Тогос-уул | Гэр хороолол АТП-100 | 0.4 | 1.8 | 36 | Багануурт |
| 26 | Нугын тал | Гэр хороолол АТП-120 | 0.4 | 1.8 | 81 | |

КАДАСТРЫН ЗУРАГ ХИЙГДЭХ ДЭД СТАНЦУУДЫН ЖАГСААЛТ

| Багануур салбарын эзэмшлийн дэд станц | | | |
|---------------------------------------|--------------------|---------------------|---------------------------------|
| Д/д | Дэд станцуудын нэр | Хүчдэлийн түвшин | Тайлбар |
| 1 | Байдлаг | 35/10 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 2 | Цэнхэрмандал | 35/6 кВ | Хэнтий аймаг Цэнхэрмандал сум |
| 3 | ХБУ | 35/10 кВ | Хэнтий аймаг Дэлгэрхаан сум |
| 4 | Тариа бригад | 35/0.4 кВ | Хэнтий аймаг Дэлгэрхаан сум |
| 5 | ТП-1 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 6 | ТП-2 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 7 | ТП-3 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 8 | ТП-4 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 9 | ТП-5 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 10 | ТП-6 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 11 | ТП-7 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 12 | ТП-8 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 13 | ТП-9 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 14 | ТП-10 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 15 | ТП-11 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 16 | КТПН-12 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 17 | КТП-13 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 18 | КТП-14 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 19 | ТП-15 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 20 | ТП-16 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 21 | КТП-17 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 22 | КТПН-18 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 23 | КТП-19 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 24 | ТП-20 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 25 | ТП-21 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 26 | ТП-22 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 27 | ТП-23 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 28 | ТП-24 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 29 | ТП-25 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 30 | ТП-26 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 31 | ТП-27 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 32 | ТП-28 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 33 | ТП-29 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 34 | ТП-30 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 35 | ТП-31 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 36 | АТП-32 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 37 | КТП-33 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 38 | ТП-34 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |

| | | | |
|----|----------|-------------|-------------------------------------|
| 39 | ТП-40 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 40 | ТП-41 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 41 | КТП-44 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 42 | ТП-46 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 43 | КТП-47 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 44 | АТП-48 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 45 | ТП-50 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 46 | КТП-51 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 47 | КТП-52 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 48 | КТП-55 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 49 | КТП-56 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 50 | АТП-58 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 51 | АТП-59 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 52 | КТПН-60 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 53 | КТПН-72 | 10/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 54 | АТП-75 | 10/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 55 | АТП-81 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 56 | КТПН-82 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 57 | АТП-90 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 58 | КТПН-91 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 59 | АТП-94 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 60 | АТП-98 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 61 | АТП-100 | 10/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 62 | АТП-102 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 63 | АТП-103 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 64 | КТПН-107 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 65 | КТПН-108 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 66 | КТПН-111 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 67 | АТП-117 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 68 | АТП-120 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 69 | АТП-130 | 6/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 70 | АТП | 35/0.4 кВ | Улаанбаатар хот Багануур дүүрэг |
| 71 | АТП-1 | 10/0.4 кВ | Хэнтий аймаг Хэрлэнбаянулаан тосгон |
| 72 | АТП-1 | 10.5/0.4 кВ | Хэнтий аймаг Дэлгэрхаан сум |
| 73 | АТП-2 | 10.5/0.4 кВ | Хэнтий аймаг Дэлгэрхаан сум |
| 74 | КТП-3 | 10.5/0.4 кВ | Хэнтий аймаг Дэлгэрхаан сум |
| 75 | АТП-4 | 10.5/0.4 кВ | Хэнтий аймаг Дэлгэрхаан сум |
| 76 | АТП-8 | 10.5/0.4 кВ | Хэнтий аймаг Дэлгэрхаан сум |
| 77 | АТП-7 | 10/0.4 кВ | Хэнтий аймаг Жаргалтхаан сум |
| 78 | АТП-1 | 10/0.4 кВ | Хэнтий аймаг Жаргалтхаан сум |
| 79 | АТП-2 | 10/0.4 кВ | Хэнтий аймаг Жаргалтхаан сум |
| 80 | АТП-1 | 6/0.4 кВ | Хэнтий аймаг Цэнхэрмандал |
| 81 | АТП-2 | 6/0.4 кВ | Хэнтий аймаг Цэнхэрмандал |
| 82 | АТП-5 | 6/0.4 кВ | Хэнтий аймаг Цэнхэрмандал |
| 83 | АТП-6 | 6/0.4 кВ | Хэнтий аймаг Цэнхэрмандал |
| 84 | АТП-10 | 6/0.4 кВ | Хэнтий аймаг Цэнхэрмандал |
| 85 | АТП-1 | 6/0.4 кВ | Төв аймаг Мөнгөнморьт |
| 86 | АТП-2 | 6/0.4 кВ | Төв аймаг Мөнгөнморьт |
| 87 | АТП-3 | 6/0.4 кВ | Төв аймаг Мөнгөнморьт |

Тав. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

2019 оны дугаар сарын-ны өдөр

БЗӨБЦТС ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Тавинбэх танаа

1. Бид, *[тендерт оролцогчийн нэр]*, *[гэрээний нэр ба дугаар]*-ыг *[тендерийн үнийг тоогоор болон үсгээр]* төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана. 4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна. 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг |

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- арилгах** гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх** 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь** 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх** 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги** 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах** 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага

17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

18. Гэрээг цуцлах

18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;

(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг /цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах

бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

20. Гүйцэтгэлээс чөлөөлөх

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

| | |
|-----------------|--|
| ГЕН 2.1 | Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудын кадастрын зургийн гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер дугаар: ХАН№19/51</i> |
| ГЕН 2.1 | Ажил нь <i>БЗӨБЦТС ТӨХК-ний Багануур ЦТС салбарын эзэмшлийн ЦДАШ, дэд станцуудын кадастрын зураг хийж, харьяа засаг захиргааны газрын албаны мэдээллийн санд бүртгэх.</i> <i>Ажлын талбай нь Улаанбаатар хот Багануур дүүрэг, Хэнтий аймаг Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал сум, Төв аймаг Мөнгөнморьт сум</i> |
| ГЕН 3.1 | Төслийн менежер нь Багануур Цахилгаан Түгээх сүлжээ салбарын ашиглалт засварын инженер Э.Төмөрсүх |
| ГЕН 4.1 | Ажил эхлэх өдөр 2019-09-01 Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр 2019-11-01 |
| ГЕН 7.1 | Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана. |
| ГЕН 9.1 | Чанарын баталгаат хугацаа 365 хоног байна. |
| ГЕН 13.1 | Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,5% байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 10% байна. |
| ГЕН 16.1 | Төлбөрийг 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор төлж барагдуулна. |
| ГЕН 17.1 | Газрын гэрчилгээг 2019-10-20-ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг 2019-11-01 -ний дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ 10,000,000 байна. |
| ГЕН 19.1 | Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын 50-иар тооцно. |

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.